

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ  
НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР**

**1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны мэдээлэл:**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 1 удаа хийж, “Ой тэмдэглэх сум, байгууллагад зөвшөөрөл олгох тухай”, “Аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаар батлах тухай”, “Төрийн шагналд уламжлах тухай”, “ Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох мэдэгдэлд санал өгөх тухай”, “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай”, “Худалдах хөрөнгийн доод үнэ тогтоох тухай”, “Хөрөнгө актлах тухай” зэрэг 8 тогтоолуудыг гаргаж биелэлтийг хангуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.



Баруун бүсийн аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультаан ажилтнуудын туршлага солилцох уулзалт, спортын тэмцээнийг 2018 оны 06 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Улиастай суманд зохион байгууллаа. Тус уулзалтаар Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтэц зохион байгуулалт, гаргаж буй бодлого, тогтоол шийдвэр, анхан болон дунд шатны хурлын байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, иргэдийн оролцоо, өргөдөл хүсэлтийг шийдвэрлэж буй байдлын талаар туршлага солилцон, цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцэв. “Эмэгтэйчүүдийн эрх ба байгаль орчны шударга ёс” орон нутгийн эмэгтэйчүүд, Төрийн бус байгууллага, бүлгүүдийг чадавхжуулах сургалт 06 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, сургалтаар орон нутагт байгаль орчны чиглэлээр тулгамдаж буй асуудлууд, тэдгээрт эмэгтэйчүүд, бүлгүүдийн оролцоо хэр байгаа талаар судлан шинжилж, бүлгүүдийг шийдвэр гаргагчдад ямар арга замаар нөлөөлөх тухай хэлэлцүүлэг зохион байгуулав.



Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлыг эрчимжүүлж, уялдааг хангах”

сургалтыг цахим хэлбэрээр аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимд 2018 оны 06 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалтаар уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах асуудлууд болон уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлүүд мөн байгаль орчинд тулгамдаж буй асуудлуудын талаар тодорхой мэдээллүүдийг хүргэж, санал солилцлоо.



“Завхан аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” дэд хөтөлбөр, “Хүүхдэд ээлтэй Завхан” дэд хөтөлбөр, “Жимс жимсгэнэ”, “Хүнсний ногоо”, зэрэг хөтөлбөрүүдийн төслийг аймгийн Иргэний нийгмийн 21 байгууллагуудаар 06 дугаар сарын 26-



ны өдөр хэлэлцүүлж, 21 Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл солилцов.

## **1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл:**

Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил”-ийн хүрээнд Завхан аймаг “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах жил” болгон зарлаж, ард иргэдийнхээ санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг байх, иргэдээрээ төрийн ажлыг үнэлүүлдэг байх, иргэн-төвтэй төртэй болох зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд Төрийн байгууллагуудын удирдлага, албан хаагчдын сахилга хариуцлага чадавхыг дээшлүүлэх бүсийн сургалтыг Дөрвөлжин суманд зохион байгуулж, говийн бүсийн 5 сумын 160 орчим төрийн албан хаагчид оролцлоо. Энэ үеэр зөвлөгөөнд оролцогч сум бүр 2018 онд улс, аймаг, сумаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд тодорхой сэдвээр илтгэл



тавьж, 2017, 2018 онд шинээр санаачилсан ажлаа тайлагнаж харилцан туршлага солилцлоо. Мөн бодлогын бичиг баримт боловсруулах, тайлагнах, төлөвлөх, албан

хэрэг боловсруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, харьцаа хандлага, төрийн албаны стандарт, зөрчлийн тухай хууль болон захирамж, тушаалын эрх зүйн үндэслэл зэрэг сэдвээр нэгдсэн сургалт зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын санаачилгаар "Сайн эмч" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэн аймагт эмч, эмнэлгийн ажилчдынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхээс гадна олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийж байна. Action Mongolia Франц Монголын хамтарсан нийгэмлэгээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт



дурангийн мэс заслын аппаратыг 6 сарын 12-нд, нүдний мэс заслын микроскоп хүлээлгэн өглөө. Завхан аймгаас дурангийн мэс заслын хагалгаанд орохоор жилд дунджаар 500 гаруй иргэн Улаанбаатар хотыг зорьж, нэг иргэнээс 2.5 сая орчим төгрөгийн зардал гардаг байна. Тэгвэл дурангийн хагалгааг орон нутагтаа 400 мянган төгрөгөөр хийлгэдэг болсноор аймгийн хэмжээнд жилдээ 1.2 тэрбум төгрөг хэмнэнэ гэсэн тооцоо гарчээ. Дотооддоо болон Франц, ОХУ-д бэлтгэгдсэн эмч нар орон нутагтаа ажиллахаас гадна хагалгааны өрөөнүүдээ ч засч тохижуулжээ.

Ирээдүйд нутаг орныхоо хөгжлийг тодорхойлох шилдэг боловсон хүчин бэлтгэхийн тулд багш нарын мэдлэг, ур чадвар сайн, хүүхдийн төлөө гэсэн чин сэтгэлтэй байх ёстой. Тиймээс "Сайн багш" дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа Завхан аймаг сургуулийн өмнөх боловсролын удирдах ажилтан, багш, ажилчдад зориулсан "Багшийн сэтгэл хүүхдэд" цогц үйл ажиллагааг Тосонцэнгэл суманд зохион байгуулж, "Багшийн сэтгэл хүүхдэд" багш, удирдах ажилтны сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн багш нарт гурван удаа зохион байгуулсан бол энэ удаад сургуулийн өмнөх боловсролын багш нараа чадавхжууллаа. Багш, ажилтны хөгжлийг дэмжих, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, бага насны хүүхэдтэй ажиллах арга зүйг эзэмшүүлэх зорилготой энэхүү сургалтад сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллаж буй 600 гаруй



албан хаагч оролцлоо. Энэ үеэр цэцэрлэгийн эрхлэгч, багш, туслах багш, тогооч, үйлчилгээний ажилчид, харуул хамгаалалтын ажилтнуудад цогц сургалт зохион байгуулснаараа онцлог байлаа.

Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжих, хамгаалуулах үндсэн эрхийг хангахад тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Бидний хөгжил, хамгаалал” сэдэвт урд бүсийн хүүхдүүдийн анхдугаар чуулга уулзалтыг зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаанд Цагаанчулуут, Отгон,



Шилүүстэй, Цагаанхайрхан сумын хүүхдүүд оролцож “Хорт зуршлаас өөрсдийгөө хамгаалахад хүүхэд бидний оролцоо”, “Хүмүүжил төлөвлөө сайжруулахад хүүхдийн оролцоо”, “Цахим орчны зүй зохистой хэрэглээнд суралцахад бидний оролцоо”, “Үе тэнгийн хүчирхийлэл дарамтыг бууруулахад хүүхдийн өөрийн оролцоо” сэдвүүдээр хэлэлцүүлэг явуулж, ажлын төлөвлөгөө гаргалаа. Хүүхдүүдийн төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэхэд сургууль болон сум орон нутгийн засаг захиргаа дэмжиж хамтран ажиллахаар боллоо.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

### **2.1. Татвар төлөлтийн байдал:**

Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 115.3 хувийн биелэлттэй, 4 тэр бум 265.6 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 43.6 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 4.5 хувь, ашигт малтмал ашигласаны төлбөр 18.6 хувь, бусад нэр төрөл 33.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 74.6 хувь буюу 3 тэрбум 183.3 сая төгрөгийг орон нутгийн орлого, 25.4 хувь буюу 1 тэрбум 82.3 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр эхний 5 сарын байдлаар гүйлгээнд 12 тэрбум 329.8 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 65.8 мянган иргэний 84.6 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 19.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн дүнгээр 55.0 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 3.3 хувь буюу 1.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл

дунджаар ХААН банк 1.8%, Хас банк 0.58-2.0%, Төрийн банк 1.5%, Капитал банк 1.5% байна.

## ГУРАВ. ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

### 3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа:

Завхан аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авто тээврийн төв, орон нутгийн Шинэ Завхан" телевизтэй хамтран "Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл-2018" аяны нээлтийн арга хэмжээг 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Улиастай сумын Баруун бүсийн худалдааны төвийн гадна талбайд зохион байгуулж, нээлтийн ажиллагаанд хамтран ажиллагч байгууллагуудын удирдлагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл, иргэд оролцлоо. Арга хэмжээний үеэр оролцогч нарт зам тээврийн осол хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд соёлтой, хариуцлагатай оролцох талаар гарын авлага, санамж тарааж, үүний гол зорилго орон нутгийн замд гарч байгаа зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, осол хэргийн гаралт, үүнээс үүдэлтэй нас баралт, гэмтлийг багасгах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдэж байгаа юм.



"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" сэдэвт сургалт Хар нуурын сургалтын бааз дээр 2018 оны 06 сарын 05-07-нд сургалтыг "Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага" (IDLO)-аас зохион байгуулж, орон нутгийн байгууллагуудыг өргөнөөр оролцуулж, хамтран суралцах, харилцан туршлага хуваалцах боломжийг олгосноороо, сургалтыг чиглүүлэгч багш нар нь сургалтын шинэлэг арга зүйг ашиглаж явуулснаараа бусад сургалтаас онцлог, ихээхэн үр дүнтэй байв.



### **3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл:**

Аймгийн хэмжээгээр 96 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 37.5 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 36.4 хувь нь бусдын өмчлөлийн эсрэг гэмт хэрэг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн тоо 25 буюу 35.2 хувиар өссөн байна.

Эхний 5 сард гэмт хэргийн улмаас 2 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 6 дахин буурсан байна. Оны эхнээс өссөн дүнгээр 1901 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1536 буюу 44.7 хувиар буурсан байна. Эрүүлжүүлэгдсэн хүн 278 болж өнгөрсөн оноос 7-р өссөн бол баривчлагдсан хүн 99 болж өнгөрсөн оны мөн үеийн төвшинд байгаа юм. Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 60.0 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5 пунктээр буурсан байна.

### **3.3. Архивын ажлын мэдээлэл:**

Тайлант хугацаанд 2 хөмрөгийн удирдлагын баримт бичгийг баримтын түвшинд тодорхойлон бичих, тоо бүртгэлийн программд оруулах ажлын хүрээнд 1655 хуудас баримтаас 1331 заалт, 8933 хүний нэр, 18 байгууллагын нэр, 41 PDF файл үүсгэн эх баримтыг мэдээллийн санд холболоо. Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 3 хөмрөг, 3 данс, 73 хадгаламжийн нэгжийн 4569 хуудас баримтыг сканердаж, 3 хөмрөг 3 дансны 73 хадгаламжийн нэгж, 4569 хуудас баримтыг photoshop програмд засварлалаа. 3 хөмрөгийн 418 хадгаламжийн нэгж баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж, үдэж хавтаслан холбогдох акт үйлдэж, данс бүртгэлд оруулсан. 249 иргэний хүсэлтийг хүлээн авч 634 баримт шүүж, 174 хуулбар, 116 лавлагаа тодорхойлолт 86 олгож төрийн үйлчилгээ үзүүллээ. Эрдэм шинжилгээ судалгааны ажилд 122 хадгаламжийн нэгж баримт ашиглуулсан. 2018 онд нөхөн бүрдүүлэлт хийх судалгаа хуваарийн дагуу 11 хөмрөг үүсгэгчийн 738, зураг төслийн 2, нийт 740 хадгаламжийн нэгж баримт хүлээн авч нөхөн бүрдүүлэлт хийлээ. Архивын тасгийн дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг 06 дугаар сарын 18-ны өдөр хийж, хурлаар үндсэн 5 асуудлыг хэлэлцэж 24 сумын мал тооллогын бүртгэл, малын А данс нийт 1767 баримт хүлээн авсан тухай, түүний 24 бүртгэл, хөмрөг үүсгэгч 43 байгууллагын байнга хадгалах баримтын данс, бүртгэл, устгах хэргийн акт, нийт 67 бүртгэл, устгах хэргийн акт 10, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт 2 хянан хэлэлцэж шийдвэрлэн хөмрөг үүсгэгч байгууллагуудад зөвлөгөө, заавар өгч хүргүүллээ.

### **3.4. Онцгой байдал:**

Завхан аймагт 06 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн Шүүхийн Тамгын Газрын дарга нарын “Шүүх, шүүгчдийн хараат бус аюулгүй байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Улиастай сум дахь гал түймэр унтраах аврах 43 дугаар ангийн алба хаагчид тактикийн үзүүлэх сургалтыг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, ажлын байрны галын аюулгүй байдал сэдвээр танхимын сургалт зохион байгуулсан.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан байгууллагаа сурталчлан таниулах, аав, ээжийнхээ ажил, мэргэжлээр бахархах үзлийг төлөвшүүлэх, шилдэг, тэргүүний, онц сурлагатан, авьяаслаг хүүхдүүдийг шагнаж урамшуулах зорилгоор нэгдсэн удирдамж гарган 06 дугаар сарын 01-ний өдөр “Хүүхэд-Бидний ирээдүй” өдөрлөгийг Онцгой байдлын газрын харьяа анги байгууллагын нийт алба хаагчдын хүүхдүүдийн дунд зохион байгуулж, арга хэмжээний үеэр Онцгой байдлын газрын хэмжээнд 94 өрхийн 171 хүүхдийг хамруулан “Аав, ээжийн ажил бидний нүдээр” сэдэвт гар зураг, гар урлал, шүлэг гэсэн төрлөөр болзолт уралдаан зарлаж нийт 12 хүүхдийн бүтээлийг шалгаруулж тусгай шагналаар шагнаж урамшуулсан.

**Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгаа:** График төлөвлөгөөний дагуу Монгол улсын шадар сайдын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтаар Улиастай сумын Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4 дүгээр сургуулиуд, Политехникийн коллеж, Хөгжим бүжгийн коллеж, хүүхдийн 1, 2, 4, 5 дугаар цэцэрлэгүүд, Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль зэрэг нийт 11 байгууллагад Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм стандартын Онцгой байдлын газрын даргын баталсан 2018 онд заагдах хичээл сургалтын нэгдсэн график төлөвлөгөө цаг сэдвийн дагуу Офицер бүрэлдэхүүнд 3 удаа давхардсан тоогоор 96 алба хаагчийг, ахлагч бүрэлдэхүүнд 15 удаа давхардсан тоогоор 1130 алба хаагчдыг тус тус хамруулан зохион байгууллаа.

### **ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

#### **4.1. Боловсрол, соёлын чиглэлээр:**

“Хүүхдийн эрхийг хамгаалах” өдөр 6 дугаар сарын 1-нд аймгийн Засаг дарга Д.Батсайхан "Сэтгэх чадвар"-ын улсын олимпиадад 3-р байр эзэлсэн ЧЭЛС-ийн 12-р ангийн суралцагч Б.Бадрах, аймгийн Засаг даргын нэрэмжит математикийн "Оюуны наадам"-д 1-р байр эзэлсэн Дэвшил сургуулийн 12-р ангийн суралцагч Д.Мядаг, “Эх хэлний сорилго-Идэр” уламжлалт олимпиадын “Гүн сэтгэе” эсээ

бичлэгийн төрөлд амжилттай оролцож, 1-р байр эзэлсэн ЖЦС-ийн 12-р ангийн суралцагч Н.Отгонцэцэг, монгол хэл, бичгийн олимпиадын 12-р ангийн төрөлд амжилттай оролцож, "Мөнгөн" медаль хүртсэн ЧЭЛС-ийн 12-р ангийн суралцагч Б.Цогзолмаа нарыг "Сайн оюутан" хөтөлбөрт хамруулан, 1-2 сая төгрөгийн тэтгэлэг олгох батламж олгов.

2017-2018 оны хичээлийн жилд суурь боловсролын 1226 гэрчилгээ, бүрэн дунд боловсролын 1322 үнэмлэх захиалан авч, суурь болон ерөнхий боловсрол эзэмшсэн 2380 төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох ажлыг 2018 оны 06 дугаар сарын 08-11-ний өдөр БСУГ-ын дарга, мэргэжилтнүүд хуваарийн дагуу хийж гүйцэтгэж, 1142 суралцагчдад суурь боловсролын гэрчилгээ, 1238 суралцагчдад бүрэн дунд боловсролын үнэмлэх олгож, үлдсэн 111 гэрчилгээ, үнэмлэх, 2380 суралцагчийн дүнгийн "Б" маягт, үлдсэн 47 ширхэг хавтас зэргийг архивлан БСШУСЯ-д хүлээлгэн өгч, суурь боловсролын 28, бүрэн дунд боловсролын 29 гэрчилгээ, үнэмлэх нөхөн олгож, 142.500 төгрөгийг Үндэсний үнэт цаасны газрын дансанд тушаалаа.

**4.2.Эрүүл мэнд, спортын салбар:** Сайн эмч хөтөлбөрийн хүрээнд Монос групптэй хамтран "Иргэдэд зориулсан эрүүл мэндийн өдөрлөг- 2018" 06 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулж, Завхан аймгийн эрүүл мэндийн салбарын 8 байгууллага /Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, Уламлалт анагаах ухааны төв-Рашаан сувилал, Тэс СЭМТ, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Одчим наран эмнэлэг, Үе-Залгамжлагч клиник сувилал/ иргэдэд өөрсдийн үйл ажиллагаа болон тусламж үйлчилгээний талаар танилцууллаа.



Хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 3000 гаруй гарын авлага материал тараан мэдээлэл өгч, Дотор, мэдрэл, чих хамар хоолой, үе мөч, хүүхдийн чиглэлээр үзлэг оношлогоо хийж, нийт 600 орчим иргэн хамрагдаж, "Орчин үеийн эмийн эмчилгээний стандарт ба чиг хандлага" сэдэвт 2 багц цагийн сургалтад 110 эмч, эмийн мэргэжилтнүүд хамрагдаж, Монос группын хүнс, фарм, костетик, эмнэлгийн хэрэгслийн үзэсгэлэн худалдаа, бараа бүтээгдэхүүний амталгаа зохион байгуулагдаж, 1300 иргэдэд сахарын шинжилгээг үнэ төлбөргүй хийж, нийгмийн





эрүүл мэндийн зөвлөгөөг 1500 иргэдэд өгч, 54 төрлийн дүрс бичлэгийн эвлүүлгийг 2 өдрийн турш түгээсэн. Мөн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар ажлын байрны дасгал хөдөлгөөн, Ахмадын жавхаа хамтлаг хийн дасгал хөдөлгөөнийг иргэдэд сурталчилсан.

Завхан аймгийн Засаг даргын санаачлан хэрэгжүүлж буй "Сайн эмч" хөтөлбөрийн хүрээнд Монголын сумын эмч нарын холбооны эмч, мэргэжилтнүүд ажиллаж, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн тасгийн үйл ажиллагаатай танилцаж, Тосонцэнгэл, Их –Уул, Тэс, Баянтэс, Түдэвтэй, Отгон сумын эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналт хийн арга зүйгээр хангаж, Глобал сангийн "Сүрьеэ" төслийн хүрээнд Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо, Завхан аймгийн засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар хамтран сумын Засаг дарга, эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, лаборант, МХГ-ын байцаагч, сүрьеэгийн диспансарын эмч, байгууллагуудын холбогдох нийт 70 эмч, мэргэжилтэнд "Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа" сэдэвт сургалт хэлэлцүүлэгийг зохион байгууллаа.



Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Францын Action mongolia ТББ-аас хэвлийн хөндийн OLYMPUS дурангийн мэс заслын тоног төхөөрөмж, Германы CARL ZEISS нүдний мэс заслын микроскоп, мөн нүдний үзлэгийн 5 төрлийн аппаратыг үнэ төлбөргүй суурилуулж Франц улсын 3 эмч ирж нүдний болор солих мэс засал 20 хүнд, эмэгтэйчүүдийн мэс засал 2 хүнд цөсний хүүдийн авах мэс засал 5 хүнд, оношлогооны дурангийн мэс заслыг 1 хүнд тус тус хийсэн.

#### **4.3.Нийгмийн даатгал, халамж:**

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа хүний тоо 1323 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 22(1.7%)-оор өсч 726 эмэгтэй ажил идэвхтэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 54.9 хувийг эзэлж байна.

2018 5 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхтэй хайж байгаа хүний тоо өмнөх 4 жилийн дунджаас 36(2.7%)-аар буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 16.3 хувь нь 15-24 нас, 30.0 хувь нь 25-34 нас, 29.9 хувь нь 35-44 нас, 20.6 хувь нь 45-54

нас, 2.5 хувь нь 55-59 нас, 0.7 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна. Ажилгүйчүүдийн 2.0 хувь нь боловсролгүй, 4.4 хувь нь бага, 8.8 хувь нь суурь, 52.2 хувь нь бүрэн дунд, 6.9 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 20.7 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн хэмжээнд 6 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны 1444.8 мянган хээлтэгч малын 955.6 мянга (66.1%) нь төллөжээ. Гүүний 51.8 хувь, үнээний 60.9 хувь, ингэний 31.7 хувь, эм хонины 71.2 хувь, эм ямааны 61.3 хувь нь төллөж байна. Төллөлтийн хувь өмнөх оноос 19.6 пунктээр буурсан байна. Гарсан төлийн 97.1 хувь буюу 928.1 мянган төл бойжиж байна. Төл бойжилтын хувь 1.0 пунктээр буурсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Жимс, жимсгэнэ”, 223 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор аймгийн “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрүүд болон хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Тариалангийн бүс нутгийн хил зааг, талбайн хэмжээг тогтоох тухай, “Атар-60” аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулав.



Хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлэх, хүн амын эрт ургацын хүнсний ногооны хангамжийг сайжруулах зорилтын хүрээнд зуны хүлэмжийн аж ахуй байгуулахаар аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 30.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлж, ажлын хүрээнд хүлэмж нийлүүлэх тухай цахим тендер зарлагдаж, “Бэст агро интернэшл” ХХК шалгарч гэрээ байгуулаад байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Уг хяналт-шинжилгээ, үнэлгээг нийт 10 сумын сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийж, Засаг дарга, Жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүй зөвлөгөө өгч ажиллаа.

Малын генетик нөөцийн тухай хууль, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор

Цагаанчулуут суманд 8,2 мянган мал, Эрдэнэхайрхан суманд 8,1 мянган мал, Дөрвөлжин суманд 8,5 мянган мал нийт 24,8 мянган малд ангилалт хийлээ.

Үндэсний боловсруулах үйлдвэрт 2017 онд бэлтгэн нийлүүлсэн арьс, ширний урамшууллын баримт материалыг сумдаас хүлээн авч урамшууллын мэдээллийн санд нэгтгэлээ. Дөрвөлжин, Сонгино, Их-Уул сумдаас бусад 21 сумаас бэлтгэн нийлүүлсэн 132795 ширхэг арьс, ширний холбогдох баримт материалыг архивлан ХХААХҮЯамны харьяа Мал хамгаалах санд хүргүүлээд байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, хөдөөгийн хүн амыг ундны усаар хангах зорилгоор Улсын төсвийн 94,9 сая төгрөгийн хөрөнгөөр 5, Орон нутгийн хөрөнгө оруулалтын 75 сая төгрөгөөр 5 бүгд 10 инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг сумдын захиалгын дагуу гаргуулахаар “Тэсийн бүрд” ХХКомпанитай гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын 01 ний өдрийн А/228 тоот Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай захирамжаар малын халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, лабораторийн оношилгоо, шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт хийх захиалгат арга хэмжээг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх үүрэг чиглэл өгөгдсөний дагуу арга хэмжээг зохион байгуулж байна.

Мерси Кор Олон улсын байгууллагын дэмжлэгээр сумдын 57 мал эмнэлэг үржил үйлчилгээний нэгжид мал үзлэгийн 162,5 сая төгрөгийн өртөг бүхий хашаа олгож, үйл ажиллагаа явуулах таатай нөхцөлөөр хангав.

Мал эмнэлгийн нян судлалын лабораторид Алдархаан, Цагаанчулуут, Эрдэнэхайрхан, Тэлмэн, Улиастай, Шилүүстэй, Ургамал, Тосонцэнгэл сумдаас 22 дээж материал ирүүлснийг шинжлэхэд 16 галзуу оношлогдсон тул өвчин гарсан сумдад ажлын хэсгүүд томилон ажиллуулж, зааврын дагуух арга хэмжээг хэрэгжүүллээ.

“ЗАВХАНЫ УЛААН ХАЛЬСТ САРМИС” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд улаан хальст сармис тариалах туршлагатай Улиастай, Алдархаан сумдын тариаланчдад “Улаан хальст сармисны үр үржүүлэх” гэрээ байгуулан нийт 88 кг үрийг 26 аж ахуйн нэгж, иргэнд гэрээ байгуулан олгосноор 6.0 га-д тариалалт хийснээр тариалах талбайн хэмжээ нэмэгдэж байна.

Улаан хальст сармисны үрийг эрүүлжүүлэх, үржүүлэх зорилгоор “Монгол ногоо” хөтөлбөрийн газартай хамтран 100 ширхэг булцуунд вирусийн шинжилгээг Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнд хийлгүүлж эрүүл булцууг сонгон авч, эрүүл үр үржүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлд үрийн сармисны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 20.0 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлсэн бөгөөд энэ арга хэмжээний хүрээнд нийт 400 кг үрийн сармисны нөөц бүрдүүлэхээр Улиастай сумын 4 тариаланчтай “Улаан хальст сармисны үр худалдан авах тухай гэрээ” байгуулан, урьдчилгаа олгон, үрийн нөөц бүрдүүлэх арга хэмжээг авлаа.

## **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

### **6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:**

Нэн ховор ургамал болох Вансэмбэрүү цэцгийг түүж, худалдахаас урьдчилан сэргийлж Алдархаан сумын богдын гол багийн Рашаантын голын 15 айл өрхөд 2018 оны 06 дугаар сарын 7-10-ны өдрүүдэд Зөрчлийн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Амьтны тухай хууль, тогтоомжийг сурталчилж, холбогдох хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээг танилцуулсан.



Аймгийн хэмжээнд орчны бохирдлыг бууруулах, иргэдэд зөв дадлыг

төлөвшүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй “Эко Завхан” аяны хэрэгжилтийг хагас жилийн байдлаар дүгнэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/288 дугаар захирамжаар байгуулж, сум, албан байгууллагуудын хэрэгжүүлсэн ажлын тайланг хүлээн авч байна.



Аймгийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээгээр эхний хагас жилийн байдлаар нийт 2851,3 га талбайгаас

1004,3 тонн хог хаягдал цэвэрлэж, 3291 айл өрх, 343 албан байгууллагын 3796 гаруй албан хаагчид хамрагдсан дүнтэй байна. Мөн нийтийн их цэвэрлэгээний үеэр 70940

гаруй малын сэг зэм, 1012 бүртгэлгүй буюу золбин нохойг устгаж, эзэнтэй нохойг бүртгэлжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсан.



Химийн хорт болон аюултай бодис ашиглаж үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”, “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах устгах журам”-ын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаад тандалт судалгаа хийсэн.

“Хөрс хамгаалах үндэсний өдөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлуудыг 05 дугаар сарын 04-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлж, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлж ажилласан.



Ногоон байгууламжийн тарилт, усалгаа, арчилгааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх хүний нөөцийг сайжруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Шаамар сумын МСҮТ-д “Цэцэрлэгжүүлэгч”-ийн ангид 12 сум, 14 албан байгууллагын нийт 30 хүнийг сургаж, мэргэжлийн үнэмлэх олгосон.

Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/332 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар гадаргын усны чанарыг бохирдлын индексээр үнэлсэн.



Үнэлгээгээр:

Усны бохирдлын индекс			
Нэр	2018 оны эхний хагас жил		
	УБИ	Усны чанарын зэрэг	ангилал
Богд гол	0.31	II	цэвэр
Чигэстэй гол	0.30	I	маш цэвэр
Буянт гол	0.20	I	маш цэвэр
Идэр гол /Идэр сум/	0.24	I	маш цэвэр
Идэр гол /Тосонцэнгэл сум/	0.26	I	маш цэвэр
Тэс гол	0.23	I	маш цэвэр
Хүнгүй гол	0.45	II	цэвэр
Завхан гол	0.34	II	цэвэр
Тээл гол	0.39	II	цэвэр
Хар нуур	0.27	I	маш цэвэр

Монголын эмэгтэйчүүдийн сантай хамтран 2018 оны 06 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Улиастай суманд “Эмэгтэйчүүдийн эрх ба байгаль орчны шударга ёс” сэдэвт сургалт зохион байгуулж, сургалтанд Дөрвөлжин, Ургамал, Улиастай сумдын төлөөлөл 30 иргэн оролцсон.



Аймгийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, зорин ирэх аялагч, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Аймгийн 9 гайхамшиг”-ийг тодруулах ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар зохион байгуулж байна.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг манай аймгийн 5 сумын 53043.53 гектар талбайд олгох боломжтой гэсэн мэдэгдэлд аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 1/726 дугаар албан бичгээр саналаа хүргүүлээ.

## **6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:**

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6 сарын 1-ний байдлаар оны үнээр 4895.4 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 6.2 хувиар буюу 323.2 сая төгрөгөөр буурсан байна. Нийт үйлдвэрлэлээс аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл нь 3666.3 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 1229.1 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 64.9 %, хүнсний үйлдвэрлэл 23.6 %, хувцас үйлдвэрлэл 7.3 %, модон эдлэл үйлдвэрлэл 2.3 %, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.2%, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.9%, болк, тоосго 0.4%, бусад үйлдвэрлэл 0.4 %-ийг тус тус эзэлж байна.

**6.3. Дэд бүтцийн чиглэлээр:** Барилгын хөгжлийн төвийн инженерүүдтэй хамтран Цэцэн-Уул сумын 160 хүүхдийн сургууль спорт заал, Их-Уулын сумын 640 хүүхдийн хичээлийн байр, спорт заал, ГХБХБГ-ын конторын барилгын засвар, Тосонцэнгэл сумын гадна инженерийн шугам сүлжээний хэрэглээг нэмэгдүүлэх цэвэр, бохир усны шугамын ажилд хяналт хийн гарсан зөрчлыг тухай бүр үүрэг даалгавар өгч ажиллаа. Мөн улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа Эрдэнэхайрхан, Отгон сумын ЭМТ-ийн барилгад хяналт тавин ажиллаа.

800 хүний суудалтай ХЖТ, ГХБХБГ-ын контор, Отгон, Эрдэнэхайрхан сумын ЭМТ, Улиастай хотын камержуулах ажил, Баянтэс сумын сургуулийн барилгын засвар, Цагаанхайрхан сумын ЗДТГ, Ургамал сумын сургуулийн 160 хичээлийн байр, спорт заалны барилгын засвар, Тэлмэн сумын хичээлийн байрны засвар, Их-Уул сумын 640 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулсан.

Мөн шинээр эхлэх болон их засвар хийгдэх 6 барилга байгууламж дээр ажил эхлүүлэх үргэлжүүлэх зөвшөөрөл олгосон.

Аймгийн Засаг даргын мэдээллийн цаг дээр барилга угсралт их засварын ажлын талаар ГХБХБГ-ын дарга мэдээлэл хийсэн.

БХБЯ, ОБЕГ-с газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ, үнэлгээ хийх аргачлал сэдэвт сургалтанд ГХБХБГ, аймгийн ерөнхий архитеторын хамруулсан.

Баянхайрхан сумын 160 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилга Харгант ХХК, Ургамал сумын 160 хүүхдийн хичээлийн байрны засварын ажил тус тус комисс ажиллаад байна.

Мөн барилгын хөгжлийн төвд 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилга угсралтын ажлын явцын мэдээг гарган цахим хаягаар хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд шинээр байгуулагдсан, буюу хуучин ажиллаж байгаа ус дулааны дэд бүтэцтэй сумд болон хариуцан ажиллаж байгаа байгууллагуудын судалгааг гарган хот суурины усан хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн.

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**